

БАТЛАВ:	БАТЛАВ:	БАТЛАВ:
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Ц.МӨНХ-ОРГИЛ	П.СЭРГЭЛЭН	С.БЯМБАЦОГТ

**“НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
УРГАМЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ”-Г
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын “Хүнс, хөдөө аж ахуйн Ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээ”-г соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах дараахь үндэслэл, шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 3.1.5-д “эдийн засгийн үр ашигтай, хөрсний үржил шимд ээлтэй таримал, сортыг нутагшуулах, бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ирээдүйтэй, баталгаажсан таримлын үрийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн үрээр хангах, үр, сортын тариалан, үрийн аж ахуйн тогтолцоог сэргээн хөгжүүлэх” гэж, 3.1.11-д “үр тариа, буурцагт болон бусад таримлын төрөл, сортыг нэмэгдүүлэх, буудай, төмс, хүнсний ногоо, тосны ургамлын үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах, улмаар экспортын чиг баримжаатайгаар хөгжүүлэх” гэж, “Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилтын 2.41-д “Газрын үржил шим, үр өгөөж, таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлж, үрийн сорт чанарыг сайжруулах замаар га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.” гэж гэж тус тус заасан байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн санал, дүгнэлтэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын “Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээ”-нд нэгдэн орохыг дэмжиж, Засгийн газарт гарын үсэг зурахыг зөвшөөрсөн байна.

1.2.Практик шаардлага

Дэлхийн хүн амын өсөлт, уур амьсгалын сөрөг өөрчлөлтүүд, нийгэм улам бүр даяаршиж байгаа энэ цаг үед биологийн гаралтай, чанартай, эрүүл хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гол арга зам нь шинэ таримал сорт хэлбэрүүдийг өргөнөөр бий болгох замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх явдал болоод байна. Зөвхөн Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор 2015-2020 онд цаг уур +1 хэмээр дулаарах тутамд үр тарианы ургац 10%-иар буурах төлөвтэй байна.

Дэлхий даяар тариалангийн газрыг нэмж өргөжүүлэх боломж хязгаарлагдмал болсон өнөөгийн нөхцөлд тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх хамгийн дэвшилтэт, оновчтой арга зам нь хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг бүрэн ашиглах гэдгийг хүлээн зөвшөөрч түүнийг хамгаалж хойч үедээ өвлүүлэн үлдээх, орчин үеийн

селекци, биотехнологийн аргыг хослуулан шинэ сорт хэлбэрүүд бүтээж үйлдвэрлэлд өргөн нэвтрүүлэх чиглэлээр эрчимтэй ажиллаж байна.

НҮБ-ийн ХХААБ-ын 55-р чуулганаар Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн тухай олон улсын гэрээг 2001 онд баталж, энэ гэрээ нь 2004 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар дэлхийн 143 орон элсээд байна. Уг гэрээгээр хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг олон улсын хэмжээнд чөлөөтэй солилцох, судалж ашиглах боломж бий болгож, тэдгээрийг хамтран хамгаалах, үр ашигтай ашиглах замаар даян дэлхийн хүнсний хангамж аюулгүй байдал, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах, олон зуун жилийн явцад тухайн улс орны тариаланчид, судлаачдын хуримтлуулсан уламжлалт мэдлэг, ургамлын генетик нөөцийг ашигласнаас бий болсон ашгаас тэдэнд буцааж хүртээх олон улсын тогтолцоо бий болгох харилцаа зохицуулж байгаа болно.

Иймд Монгол улсын хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн сан хөмрөгийг хамгаалах, хүнсний бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, тооны хувьд бидний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахуйц сортыг бий болгох, тэдгээрийн олон янз байдлыг хамгаалах болон таримлын генетик нөөцийг тогтвортой ашиглах талаарх дэлхийн бусад орнуудтай хамтран ажиллах, цаашлаад ашиг хүртэх боломжийг бүрдүүлэх үндэсний эрх зүйн зохицуулалт бий болгох хэрэгцээ, шаардлагаас үүдэн Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн тухай олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох асуудал нэн чухал тавигдаж байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Уг хуулийн төслөөр Монгол орны нутаг дэвсгэр дээрх хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг хамгаалах, хадгалах, ашиглах, ашигласнаас гарах ашгийг хуваарилах талаар дотоодын эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс Хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээг соёрхон батлахтай холбоотой харилцааг зохицуулах юм. Хуулийн төсөл нь 1 зүйлтэй.

Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн

Энэхүү хууль батлагдснаар дараах эерэг үр дагаварууд гарна:

1. Таримал ургамлын генетик нөөцийн талаар баримтлах бодлого, чиглэл, стратеги, үйл ажиллагааг өөрийн орны онцлогт нийцүүлэн тодорхойлсон эрх зүйн орчин бүрдэнэ.

2. Монгол Улсын таримал ургамлын генетик нөөцөд нэвтэрсэн болон ашигласнаас олсон татвар, хураамжийн орлогыг тодорхой хувийг Засгийн газрын тусгай санд төвлөрүүлж, энэхүү нөөцийг бүртгэх, судлах, хадгалах, хамгаалах, доройтол, мөхлөөс сэргийлэх, бататган сайжруулахад дэмжлэг үзүүлж, биотехнологийн бизнесийг хөгжүүлэх боломжийг нээнэ.

3. Гадаад улс орнуудтай мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх, чадавхиа бэхжүүлэх чиглэлээр олон улсын түвшинд хамтран ажиллах, энэ чиглэлийн хөрөнгө оруулалтыг татах боломж нэмэгдэнэ.

Тус хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй гэж үзэж байгаа болно.

Дөрөв.Хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Уг хуулийн төсөл нь Монгол улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд ба хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар сарын ..-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГЫН “ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН УРГАМЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ”-Г СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын “Хүнс, хөдөө аж ахуйн Ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээ”-г соёрхон баталсугай.

ГАРЫН ҮСЭГ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН УРГАМЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас санаачлан ургамлын генетик нөөцийг хадгалж хамгаалах, тогтвортой ашиглах замаар даян дэлхийн хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээ (ХХААУГНОУГ)-г баталж, 2004 оноос үйлчилж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар дэлхийн 143 орон нэгдээд байна.

Энэхүү гэрээний үндсэн зорилго нь хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг хадгалах, тогтвортой ашиглах, түүнийг ашигласнаас бий болсон ашгийг Биологийн Олон Янз Байдлын Конвенцийн зарчимтай (CBD) уялдуулан шударга, тэгш хуваарилах замаар хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, хүнсний аюулгүй байдлыг хангах юм.

Гэрээнд нэгдэн орсноор монгол орны тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжүүлэхэд нэн шаардлагатай байгаа ган халуун, өвчин хортонд тэсвэртэй, ургацын чадавхи сайн, чанарын өндөр агууламжтай хүнс, тэжээл, тос техникийн зэрэг хэрэглээний өргөн чиглэлээр ашиглах шинэ таримал сорт хэлбэрүүдийг бий болгох, сайжруулахад дэлхийн ургамлын генетик нөөцийн сангаас чөлөөтэй ашиглах боломж бүрдэнэ. Түүнчлэн, ургамлын генетик нөөцийг хадгалж, ашиглах ажлыг сайжруулахад шаардлагатай техник технологи, хөрөнгө санхүү болон боловсон хүчнийг чадавхижуулах чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэг болон бусад донор байгууллагуудын дэмжлэгийг бүрэн хүртэх өргөн боломж нээгдэнэ.

Монгол орны өргөн уудам нутагт хүнс, хөдөө аж ахуйн төрөл бүрийн таримал ургамал тариалах, цаашид гадаадад экспортлох ихээхэн нөөц бололцоо болон бизнесийн орон зай, эрэлт хэрэгцээ байгаа ба хөрс, уур амьсгалын экологийн өөр бүсүүдэд дасан зохицсон таримал болон тэдгээрийн зэрлэг овог, төрөл зүйлийн генетик нөөцийг хамгаалах, хадгалах, ашиглах, мэдээллийн сан байгуулах ажлын эрчимжүүлэхэд төрөөс тодорхой бодлого, хөтөлбөрөөр дэмжих, олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгийг өргөнөөр хүртэх боломж бүрдүүлэх, тухайлбал олон улсын хэмжээнд бий болоод байгаа энэхүү бодит нөхцөл байдалтай холбогдуулан энэхүү гэрээнд нэгдэн орох нэн шаардлагатай байгаа юм.

Манай орны хувьд ХХААУГН-ийн тухай олон улсын гэрээнд нэгдэн ороогүйн улмаас 2010 онд УГНОУГ-г хэрэгжүүлэх хүрээнд бий болсон сангаас төсөл авахаар манай улс сонгон шалгаруулалтад саналаа хүргүүлсэн боловч энэхүү боломжийг алдсан.

Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээг соёрхон батлахад ХХААБ-ын бүх гишүүд, ХХААБ-ын гишүүн бус боловч НҮБ-ын гишүүн бүх улсууд эсвэл түүний мэргэжлийн агентлагууд, мөн Олон Улсын Атомын Энергийн Агентлагт тус тус нээлттэй бөгөөд улс орнууд хувьд ямар нэгэн мөнгөн төлбөрийн үүрэг хүлээдэггүй болно.

Цаашид хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг хадгалж хамгаалах, судалж ашиглах чиглэлээр НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлэх үйл ажиллагаа, дэмжлэгүүд нь энэхүү олон улсын гэрээний үзэл баримтлалаар явагдах болсныг ХХААБ-аас онцлон тэмдэглэж байна. Тиймээс газар тариалангийн салбарын хөгжил, дэвшилд үзүүлэх ач холбогдлыг харгалзан энэхүү олон улсын гэрээг соёрхон батлах талаар хуулийн төслийг боловсрууллаа.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ